

## ХЯТАД—ГОНКОНГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД

Д.Баясгалан

1979 оноос Хятад орон даяар өөрчлөлт шинэчлэлтийн бодлого өрнөж улмаар гадаад харилцаагаа өргөжүүлэх "нээлттэй хаалга"-ны чиг бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэхүү арав гаруй жилийн хугацаанд Гонконг нь дэлхийн эдийн засгийн хүрээнд өөрийн олж авсан давуу тал худалдааны чөлөөт нээлттэй боомт болон өмнөд Хятадтай хөрш зэргэлдээ оршиж байгаа нөхцөл бололцоогоо ашиглан Хятадад хамгийн түрүүнд хөрөнгө оруулалт хийж худалдааны харилцаагаа өргөжүүлсэн төдийгүй Хятад, Тайвань хоёрын хооронд эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Өөрөөр хэлбэл Гонконг нь Хятад орны нийгэм-эдийн засгийн сүүлийн жилүүдийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэжээ. Нөгөө талаас Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил, газар, түүхий эд, хямд ажиллах хүчний баялаг нооц, асар их эрэлт хэрэгцээтэй том зах зээл нь Гонконгийн тилдвэр санхүү, худалдааны хөгжилд мөн таатай нөлөөлсөн юм.

Энэ хугацаанд Хятад-Гонконгийн хамтын ажиллагаа гүнд сорилтыг даван туулахад Гонконгийн асуудлаар 1989 онд Хятад-Их Британы хооронд гарын үсэг зурсан Хятадад хэвлэгдсэн Гонконгийн тухай хууль чухал ач холбогдолтой болжээ. Үүнд Гонконг нь Хятадын захиргааны бүс нутаг ба Гонконг дахь нисэхийн шинэ буудлыг Хятадад гурван жилийн хугацаагаар тодорхой хязгаартайгаар ашиглуулах, хоёр талын харилцааг тогтвортой болгох зэрэг Хятадад илт таатай нөхцөл бий болгохоор тохиролцсоны дүнд худалдаа-эдийн засгийн харилцаа нь улам эрчимтэй хөгжсөн юм.

Д.Баясгалан ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн дэдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор.

1990 онд барууны орнууд Хятадын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авч, хөгжил нь удааширч ирсэн үед Гонконг л хөрөнгө оруулалтаа урдын адил тасралтгүй

үргэжлүүлсэн юм. Иймээс Хятад-Гонконгийн худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа нь нийлмэл цогц байдлаар цэцэглэлтэнд хүрнэ гэж судалаачид үзэж байгаа юм. Хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцаа шинэ үе шатанд шилжсэн 1979 оноос Гонконгийн худалдаа-үйлдвэрийн эзэд өөрийн хөрш Гуандун мужид ихээхэн хэмжээний үйлдвэрлэлийн хэрэгсэл оруулж эхэлсэн байна. Ингэхдээ Хятадын боловсруулах үйлдвэрийн олон салбарын бүтэц, түүхий эд, газар, хямд ажиллах хүчний нөөц бололцоог нарийн тооцжээ. Гонконгийн үйлдвэрлэлийн хэрэгсэл, хөрөнгө оруулалт нь Гуандун мужийн Чжүзян голын бэлчир хавьд илүү төвлөрчээ. Хятадын электрон тооцоолон бодох, цаг, оёдол, хүүхдийн тоглоомын зэрэг үйлдвэрийн 80 гаруй хувийг Гуандун мужид шилжүүлснээр ажиллах хүч, байршил нь энд төвлөрч Гонконгийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг боловсруулах том бааз бий болжээ.

Гонкогийн аж үйлдвэрийн мэдээгээр 1992 оны 1-р сарын 30-ны байдлаар 1256 гишүүдийнх нь 510 нь буюу 40,6 хувь нь Чжүзян голын бүс нутагт хөрөнгөө оруулжээ. Тэдний 221 нь хөрөнгө оруулалтаа өргөжүүлэх саналтай, тал илүү хувь нь одоогийн хэмжээндээ байх бодолтой байна. Үүнээс гадна үйлдвэр-худалдааны 69 эзэд шинээр хөрөнгө оруулахаар бэлтгэж байна.1

Гонконгийн-худалдаа-үйлдвэрийн эздийн хөрөнгө оруулалтын хэлбэр нь "эхлээд дэлгүүр дараа нь үйлдвэр, завод барьж байгуулах" гэсэн журмаар Хятадад хэрэгжиж байна. Хятадын хямд ажиллах хүч нь Гонкогчуудад нэн тааламжтай байгаа ба Гуандун мужийн далайн эрэг хавиар 3 зая гаруй Хятад ажилчдыг хөлслөн ажиллуулж байна. Чжүзяны энэ аварга том бааз нь Гонконгийн эдийн засгийн хөгжилтөд чухал хүчин зүйл болж байгаагаас "Гонконгчуудын Чжүзяны бүс нутагт дахь аялал" нь "Чжүзяныг их хэмжээгээр үйлдвэржүүлэх аялал" болсон юм. "Гонконгийн худалдаа" сонины "Чжүзяны бүс нутгийн хөгжил" тэргүүн өгүүлэлд

Шинэчлэлт ба гадаад харилцааг хөгжүүлэх бодлого  
 13 жил явагдсан энэ хугацаанд Гонконг нь  
 өмнөд мужуудтай нягт хамтын ажиллагаа  
 хийж байна юм.

Үйлдвэрлэлийн асар том энэ бааз нь хоёр талын  
 харилцааг хөгжүүлэхэд бодит үр дүнгээ өгөх юм. 90-ээд  
 онд энэ харилцаа нь улам гүнзгийрэн хөгжиж байна''2

Мөн энэхүү тэргүүн өгүүлэлд 1992 оны эхээр  
 Гуандун мужаар айлчилсан Дэнсяопины шалган нягтлах  
 ба эдийн засгийн онцгой бүс-Шэньжэнь, Чжухайгаар  
 түүний хувийн шалгалтууд нь Гонконгийн түншүүдэд  
 болохуйц төдийгүй цаашид Гонконгтой харилцаагаа  
 доройтгож хөгжүүлэх нь чухал юм гэсэн дүгнэлтэд  
 хүргэж дурьджээ. Хятадын шинэчлэлийн бодлого ба  
 улсуудтай харилцаагаа улам гүнзгийрүүлэн  
 хөгжүүлэх, төвийн бүсийн районуудынхаа эдийн засгийн  
 төлөлийг түргэтгэхэд Гонконгийн худалдаа-үйлдвэрийн  
 дэмжлэг туслалцаа урьдын 10 жилийнхээс ч илүү  
 хурдацтай болж байна. Гонконг Хятадын хамтын хөгжил  
 дэмжлэл нь алсдаа улам ач холбогдолтой болох юм''3  
 Гонконгийн "Вэньхой" сонинд "Чжужяны бүс нутаг  
 нь газар, ажиллах хүч, шинжлэх ухаан, техникийн баялаг  
 өндөртэй. 1992 онд Гонконг-Чжужяны шинжлэх ухаан, эдийн  
 засгийн харилцаа улам хүчтэй хөгжлөө.

Гонконгийн худалдаа-үйлдвэрийн эзэд бодит үр ашигт  
 хандал ханах бус алс хэтийн хөгжилд ихээхэн анхаарал  
 тавьж байгаа тул хамтын ажиллагааны бүх салбарыг  
 хөгжүүлэхэд онцгой анхаарч байна''4 гэжээ.

Японы нэгэн томоохон институтын мэдээлснээр бол  
 Гонконг, Гуандуны эдийн засгийн харилцаа нь бие биенээс  
 салгаж болохгүйгээр нягт холбогджээ.

Хоёр талын хооронд худалдаа-эдийн засгийн харилцаа  
 хөгжихийн хамт 71 сая хүн амтай бүс нутаг бий болж, эдийн  
 засгийн харилцаа нь харилцан туслалцах, харилцан ашигтай  
 байх зарчимд тулгуурлах болсноор хятадын энэхүү бүс  
 нутгийг "Эх газар дахь их Гонконг" гэж нэрлэх болжээ.  
 Энэхүү их хөгжил нь Гонконгийг дэлхийн санхүүгийн нэгэн  
 том төв болгож улмаар санхүүгийн мэдээлэл, худалдан

борлуулах, худалдааг судлах, хөгжүүлэх асуудлыг өөрт нь төвлөрүүлж өгсөн ач холбогдолтой юм. Тухайлбал Гонконгт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний 80 хувийг Гуандунд үйлдвэрлэж байгаа ба Гонконгийн бие даасан хөрөнгө оруулалтай 16 мянган үйлдвэр, хамтарсан хөрөнгө оруулалтай 25 мянган үйлдвэр Хятадад ажиллаж байна. Үүний чухам нарийн шалтгаан нь гэвэл бусад гадаадын түншүүдээс урьтаж Гонконгчууд зоригтой, шийдмэгээр хөрөнгө оруулалт хийсэнд оршиж байгаа ба одоо хөрөнгө оруулалтын хамгийн их хувийг эзэлж байгаа юм. Хятадын гадаадтай эдийн засаг, худалдаагаар харилцах яамны мэдээгээр 1990 оны сүүл гэхэд гадаадын хөрөнгө оруулалт 37,435 млрд долларт хүрсний 23,37 миллиардыг нь (Макаогийн үйлдвэр-худалдааны хэдэн түншийг оролцуулан) Гонконгийн худалдаа-үйлдвэрийн эзэд оруулжээ. 1991 онд Гонконгийн хөрөнгө оруулалт 16,3 миллиард. гонконг долларт хүрсний дотор Гуанчжоу, Шэнь жэнь, Чжухайн бүс нутагт 800 сая долларын хөрөнгө оруулалт хийжээ. Ийм их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн явдал Гонконгийн түүхэнд урьд өмнө гараагүй байна. 5

Хятадад шинэчлэлтийн бодлого хэрэгжиж эхлэхээс өмнө өргөн хэрэглээний зарим бараа, бага хэмжээний түүхий эдийн хүрээнд Хятад Гонконгийн хооронд ачаа эргэлт явагдаж байв. Усан замын ачаа эргэлтийн хэмжээ л гэхэд 2 сая тонноос хэтрэхгүй байв. 80-аад оноос идэвхжсэн Хятад Гонконгийн өргөтгөсөн худалдааны харилцаа нь ачаа эргэлтийн хэмжээг эрс нэмэгдүүлсэн юм. 1990 он хүртэлх 10 жилийн дотор усан замын ачаа эргэлт 9 дахин өсч 18 сая тоннд хүрчээ. Гонконгийн хэвлэлийн мэдээгээр бол 1990 онд усан зам, хуурай, агаарын тээврийн тээвэрлэлтийн хэмжээ 29,53 сая тонн хүрсний дотор авто замын тээвэр эрс нэмэгдэж 1980-аад оны үетэй харьцуулахад 29 дахин өссөн нь усан тээврийн ачаа эргэлтийн хэмжээтэй ойртож ирсэн байна. Одоо өдөр бүр 18 мянган ачааны тэрэг Хятад Гонконгийн хооронд ачаа тээвэрлэж байгаа нь хил, гаалийн ажилтануудын ажлыг хүндрүүлж байгаа төдийгүй тэднийг ажлын цагаа уртасгах, амралт, баярын өдрүүдэд ч ажиллах болгож байна. Энэ нь Гонконгийн 1990 оны нийт ачаа эргэлтийнх нь 34 хувийг

Хятадтай хийж буй харилцаа эзэлж байгаагаас тодорхой харагдана.6 Гонконгоос Хятадад үзүүлж буй өөр нэг томоохон туслалцаа нь банк, санхүүгийн салбарт явагдаж байна. Гонконг өөрөө дэлхийн санхүүгийн нэгэн том төв улсаас энэ нь бүрэн бололцоотой юм.

Статийн 10 жилд Хятад улс гадаадаас 19 миллиард доллар авсны 60 хувь буюу 11,9 миллиард долларыг Гонконгоос авчээ. 1991 онд Хятадын Гуаньжоу, Шэньжэнь, Чжунхайн районуудад ихээхэн хэмжээний үйлдвэрлэлийн хэрэгсэл оруулах зорилгоор эдгээр районууд Гонконгийн 28 банкаас ихээхэн хэмжээний мөнгө авчээ. 1992 оны 3-р сарын 24 нд Синьхуа агентлагийн Гонконгийн асуудал хариуцсан хэлтэсийн дарга Чжоу Нань Хятад Гонконгийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай ярихдаа 1991 онд Хятадад оруулсан гадаадын нийт капиталын 70 хувийг Гонконг дангаараа оруулсныг онцлон тэмдэглэжээ.7 Азийн нэгжлийн банкны мэдээгээр 1985-1988 онд Хятад улс 8,3 миллиард доллар авсны 80 хувийг Гонконгийн банкаар дамжуулан авсан байна. 1991 оноос Гонконгийн "Дорнод Ази" банк өөрийн салбараа Сямэнь, Шэньжэнь, Шанхай, Гуанжоуд байгуулан ажиллуулж байна.

Хятад Гонконгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд жуулчлалын салбар ихээхэн үр ашиг өгч байгаа юм.

Гонконгийн иргэд жилд 6 сая Гонконг доллар зарцуулан, Хятадад жуулчлан ирж байна. 1978 онд Хятадад ирж байсан жуулчны тоо 1,7 сая байсны 1,5 сая нь Гонконгд амьдрагч Хятад иргэд байв.8 1990 онд Хятадад ирсэн жуулчлагчдын нийт тоо 27,46 саяд хүрсний 22 сая нь Гонконгоор дамжин ирчээ. Энэхүү жуулчлал нь Хятад улсын орлогын нэгэн эх үүсвэр болж байна. "Гонконг, Макаогийн эдийн засаг" гэдэг улирал тутмын сэтгүүлд бичсэнээр бол 1991 онд

Хятадад жуулчлагчдын тоо, түүнээс олсон ашиг нь амжилт олсон нь 1988 оныхоос хол илүү давжээ.9 1992 онд Хятад улс найрамдал нөхөрлөл-жуулчлалын он болгож олон сувгаар жуулчдыг хүлээн авчээ. Хятадын улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн хэлбэрэлтгүй өсөлтийн үр дүнд жуулчдын тоо 1991 оныхоос 10 хувиар өссөн байна. Хятадын жуулчлалаас олж буй ашгаас нь Гонконг ч өөрийн

хувиа хүртэж байгаа нь хоёр талын ашиг сонирхолд нийцэж байгаа юм.

Хоёр талын хамтын ажиллагаанд гол байр суурийг худалдааны харилцаа эзэлж байна. 1979 онд Хятад-Гонконгийн худалдааны эргэлтийн нийт хэмжээ 3,4 миллиард доллар байсан бол 1987 он гэхэд Гонконг нь Японыг гүйцэж түрүүлэн Хятадын хамгийн том худалдааны түнш нь болсон юм. 1990 онд Хятад-Гонконгийн худалдаа нь Хятадын гадаад худалдааны 35 хувийг эзлэх болжээ.

Гонконгийн засгийн газрын 1992 оны 4-р сарын 10-ны өдрийн статистикийн мэдээнээс үзвэл 1991 онд Гонконгийн барааны дамжин өнгөрөх гол зах зээл нь Хятад улс болсноор 1990 онтой харьцуулбал, Хятадаар дамжин өнгөрөх барааны нийт өртгийн өсөлт 31 хувь Хятадад орж буй барааны өртгийн өсөлт 38 хувь болжээ. Хоёр талын худалдааны дамжин өнгөрөх ачааны эргэлт 29 хувь болсон нь Америк-Гонконгийн худалдааны эргэлтээс 8 хувь илүү байна. Гонконгийн бараа Хятадаар дамжин дэлхийн зах зээлд хүрч байгаа нь Хятад-Гонконгийн эдийн засгийг хэлбэрэлтгүй бэхжүүлэх чухал хүчин зүйл болж байна. Дамжин өнгөрөх ачааны хураамжийн 25-30 хувийг Хятад улс Гонконгоос авч байгаа юм. Мөн Гонконг нь Тайвань-Хятадын улс төр, эдийн засгийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байна. 1987 оны өвөл Тайвань нь Хятадтай харилцах хориггоо тавьснаас хойш Тайваний хөрөнгө оруулалт эх газарлуу аажмаар нэвтэрч эхэлсэн юм. Гэвч Тайваний засгийн газар эх газарлуу шууд хөрөнгө оруулах, худалдаа хийхэд хязгаарлалт тавьсаар байв. Ийм үед Гонконг нь Хятад Тайваний хоорондын эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэхэд зуучлах үүрэг гүйцэтгэж эхэлжээ. 1980-аад оны дундаас 1992 оныг хүртэл Тайваний худалдаа үйлдвэрийн эзэд эх газрын хөрөнгө оруултад 4 млрд доллар болон 3 мянга гаруй объектыг барьж ашиглахад зориулж 2 млрд долларын хувь нэмэр оруулахад нь Гонконгийн тал зуучлаж өгчээ. Ингэснээр 1992 оны эхний хагаст Тайваниас гадаадад гаргах, гадаадаас оруулах капитал хорогдож, эх газартаа оруулсан хөрөнгө оруулалт нь нэмэгджээ. Тайваний засгийн газрын статистикийн мэдээгээр бол 1992 оны эхний хагаст эх газрын 65 объектод

34 сая долларыг зарцуулахдаа мөн л Гонконгоор зарцуулжээ. Ийнхүү Гонконг нь Хятад-Тайваний харилцаанд зуучлагч-гүүр болж байгаагаас гадна энэ хоёр талын барааг дамжуулах гол боомт болж байна. Одоо Хятад-Тайваний хоорондын барааны ачаа эргэлтийн дөрөвний гурав нь Гонконгоор дамжин өнгөрч байна. 1990 онд зуучилсан бараа нь 4 млрд доллар болон Гонконгийн дамжуулан өнгөрөх барааны 8 хувь болж байсан бол 1991 онд 5,5 млрд. 1992 онд 6,5 млрд. долларт хүртлээ өсчээ. 10 жилээс Хятад-Тайваний хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц, дэвшил гарахад Гонконг их хувь нэмэр оруулж байгаа юм.

Хятадын Засгийн газраас эдийн засгийн онцгой бүс байгуулахад Гуандун мужийн гурван район багтсан юм. Өнгөрсөн 10 гаруй жилд эдгээр бүс нутаг нь боловсруулах үйлдвэрээс-жуулчлал, зам-харилцаа, цахилгаан эрчим хүч, харилга байгууламж, электроны салбарт эрчимтэй хөгжиж байна.

Энэ хөгжилд хүрсэн зам нь 3-н үе шатыг туулан өнгөрчээ. Хамтын хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэл явагдсан үе нь 1979-1989 он юм. Энэ үед Гонконг нь Хятадын найдвартай тус болж хамтын ажиллагааны харилцан ашигтай замд оржээ. Хоёр дахь алхам нь 1990-1992 он юм. Энэ үед хамтын ажиллагаа нь эдийн засгийн салбарт их амжилт олсон ба Чжужяны энэхүү бүс нутгийг "Азийн тав дахь жижиг бар" гэж Гонконгчууд нэрлэх болжээ. 1992 онд Дэн-Сяопин Хятадын өмнөд мужуудын хөгжлийг шалган танилцсанаас хойш 3 дахь үе шат эхэлсэн гэж судлаачид үзэж байна. 1997 онд Гонконгийг Хятадад буцааж өгөх хүртэлх хэдхэн жилд амжиж мөнгө хуримтлуулах, удаан хугацааны найдвартай хөрөнгө оруулалтыг хятадад оруулах асар их сонирхол Гонконгийн худалдаа-үйлдвэрийн эздэд байна. Тухайлбал Хунсян тэргүүтэй Хэхэгийн нэгдэл гэхэд л эхлээд зам харилцаа, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийж хоёр гурван цахилгаан станц барьж байгуулжээ. Дараа нь Гуаньжоу-Шэньжэнь-Чжухайг холбосон зам гүүр барих ажилд орж Гонконгийн 29 банкнаас 800 сая. доллар хөрөнгө оруулан дээд амжилт тогтоожээ. Гуаньжоу-Чжухайг холбосон энэ зам нь Шэкоу-Чжухайг нэгтгэж

байгаа юм. Энэ хоёр том байгууламжийн нийт өртөг 11 млрд. гонконг доллар болж, 1995 онд дуусгана гэж тооцоолж байгаагийн зэрэгцээ Гуаньжоу Шэньжэнийн холбосон зам нь ашиглалтанд ороод байна. Энэ бүхэн нь Хятадын зам харилцааны сүлжээтэй холбогдох төдийгүй Макаотой холбогдох юм байна. Дээрх нэгдлийн эзэн Хунсян 1997 оноос хойш Гонконгоос Хятадын алдарт Хөх мөрөн хүртэл томоохон байгууламж барихаар төлөвлөж байна.

Ер нь Гонконгийн худалдаа-үйлдвэрийн эзэд эхний үеэ Хятадад ихэвчлэн зочид буудал, дэлгүүр-ресторан боловсруулах үйлдвэрийн газруудыг барьж байгуулаж байсан бол сүүлийн жилүүдэд Хятадын гадаад харилцаа өргөжсөнтэй холбогдон томоохон барилга байгууламжуудыг барих болжээ.

Гонконгийн эдийн засгийн хөгжил дэвшил нь шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэлийн чанарын төлөө өрсөлдөөнд хүргэж, биеийн хүчийг шинжлэх ухаан, техникийн ололтоор халж, дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэмжээнд хүргэж чадсан юм. Иймээс Хятадын өмнөд мужийг энэ зэрэгт хүргэн хөгжүүлж байна. Дээр өгүүлснээр 1992 оны 3-р сард Синьхуа агентлагийн Гонконгийн асуудлыг эрхэлсэн хэлтсийн дарга Чжоу Нань ярилцлага өгөхдөө Гонконгчууд шинэ онцлогтой ажиллах болсныг тайлбарласан юм. Энэ нь 1-рт; Чжужяны бүс нутагт ихээхэн хөрөнгө оруулалт хийж удаан хугацаагаар байх. 2-рт; Өмнөт Хятадын тэнгисийн бүс нутгаас Зүүн хойт Хятад, зүүн болон хойт Хятадын нутаг хүртэл өөрийн хөрөнгө оруулалт хийх. 3-рт; ресторан, дэлгүүр зочид буудал, боловсруулах үйлдвэрээс эхлээд шинжлэх ухаан техник, аж үйлдвэр, аялал жуулчлал, зам харилцаа, электрон техник зэрэг салбарыг хамран хөгжүүлснээр санхүү, фонд хуримтлалын хамтын ажиллагаагаа эрчимжүүлэн хөгжүүлэх нь чухал гэж үзэж байгаа юм гэжээ. Цаашид Хятад-Гонконгийн хамтын ажиллагаа нь Хөх мөрний сав нутаг дахь Хятадын хойт муж, зүүн районуудад өрнөх ёстой гэж үзэж байна. Энэ бүс нутаг нь мөн л хямд ажиллах хүчтэй, засгаас хэрэгжүүлж буй бодлого нь хөнгөлөлттэй нөхцөлтэй төдийгүй

боловсрол шинжлэх ухаан техникийн төвшин нь Гонконгтой ойролцоо байгааг нь түшэглэн ажиллаж байна.

Гонконгчууд Бээжинтэй худалдаа-үйлдвэрийн салбарт хамтран ажилласнаар 10 гаруй жилийн нүүр үзжээ. 1992 оны 3 -р сарын сүүлийн мэдээгээр Гонконгийн тал Бээжинд 849 үйлдвэр байгуулсан нь Хятадад оруулсан хөрөнгө оруулалтын 46 хувийг эзэлж байна. Гонконгтой хамтран ажиллах Хятадын хорооны тэргүүн Лян Циньжуны хэлснээр бол энэ нь Хятад-Гонконгийн хамтын ажиллагааны эхлэл мөн. жинхэнэ хөгжил, цэцэглэл нь алс ирээдүйд бий гэсэн 12 юм. Ляонин мужид Гонконгчууд нэлээд эртнээс хөрөнгө оруулалтаа хийж эхэлжээ. 1991 оны сүүлчийн мэдээгээр 815 барилга байгууламжийг Гонконгийн шууд хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан нь нийт мужийн үйлдвэр, аж ахуйн газруудын 48 хувийг эзэлж, нийт өртөг нь 1,69 млрд. долларт хүрч байна. Одоо Гонконг нь Хятадын хүнд үйлдвэрийн гол бааз суурь болсон Ляонин мужийн найдвартай гадаад түнш нь болжээ гэж хэлж болно. 1991 онд Гонконг 14,2 сая доллар зарцуулж Ляонины Вэньси үйлдвэрийн болд хоолойг барьж байгуулжээ. Үүний зэрэгцээ Лоянин муж нь худалдааны салбарт амжилттай хамтран ажиллаж 1991 онд барааны эргэлт нь 689 сая долларт хүрчээ. 1992 онд Гонконгт Ляонин мужийн техник, эдийн засгийн асуудлаар хамтран ажиллах зөвлөлгөөн болж гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн бүтээгдэхүүнээрээ яармаг-үзэсгэлэн байгуулжээ. Үүний үр дүнд 8 хоногт 250 хэлэлцээр байгуулж, 350 сая долларын хөрөнгө оруулалт хийхээр тохирчээ. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтад тулгуурласан барилга, байгууламж барихаар 415 сая долларын хөрөнгө зарцуулах тухай хэлэлцээр байгуулжээ. Энэ бүхэн нь цаашдын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд сайхан суурь бааз боллоо гэж хоёр талын худалдаа-үйлдвэрийн эзэд үзсэн байна. Ляонин мужаас гадна Шанхай, Хубэй, Кунминь, Хэнаньд Гонконгчууд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа юм.

Мөн одоогоор Гонконгт Хятадын хөрөнгө оруулсан 1000 гаруй үйлдвэр-аж ахуйн газар байгаа нь Гонконгийн эдийн засгийн чухал хэсгийг бүрдүүлж байна. Эдний дотроос

Экспорт шинжлэх ухаан техникийн төвшин нь Гонконгтой харьцууцгоо байгааг нь түшэглэн ажиллаж байна.

Гонконгчууд Бээжинтэй худалдаа-үйлдвэрийн салбарт хамтран ажилласнаар 10 гаруй жилийн нүүр үзжээ. 1992 оны 3-р сарын сүүлийн мэдээгээр Гонконгийн тал Бээжинд 849 үйлдвэр байгуулсан нь Хятадад оруулсан хөрөнгө оруулалтын 46 хувийг эзэлж байна. Гонконгтой хамтран ажиллах Хятадын хорооны тэргүүн Лян Циньжуны хэлснээр энэ нь Хятад-Гонконгийн хамтын ажиллагааны эхлэл юм.

Ляонин мужид Гонконгчууд нэлээд эртнээс хөрөнгө оруулалтаа хийж эхэлжээ. 1991 оны сүүлчийн мэдээгээр 815 барилга байгууламжийг Гонконгийн шууд хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан нь нийт мужийн үйлдвэр, аж ахуйн газруудын 48 хувийг эзэлж, нийт өртөг нь 1.69 млрд. долларт хүрч байна. Одоо Гонконг нь Хятадын үйлдвэрийн гол бааз суурь болсон Ляонин мужийн хамтвартай гадаад түнш нь болжээ гэж хэлж болно. 1991 онд Гонконг 14,2 сая доллар зарцуулж Ляонины Вэньси үйлдвэрийн болд хоолойг барьж байгуулжээ. Үүний зэрэгцээ Ляонин муж нь худалдааны салбарт амжилттай хамтран ажиллаж 1991 онд барааны эргэлт нь 689 сая долларт хүрчээ. 1992 онд Гонконгт Ляонин мужийн техник, эдийн засгийн асуудлаар хамтран ажиллах зөвлөлгөөн болж гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн бүтээгдэхүүнээрээ яармаг-үзэсгэлэн байгуулжээ. Үүний үр дүнд 8 хоногт 250 хэлэлцээр байгуулж, 350 сая долларын хөрөнгө оруулалт хийхээр тохирчээ. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтад тулгуурласан барилга, байгууламж барихаар 415 сая долларын хөрөнгө зарцуулах тухай хэлэлцээр байгуулжээ. Энэ бүхэн нь цаашдын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд сайхан суурь бааз боллоо гэж хоёр талын худалдаа-үйлдвэрийн эзэд үзсэн байна. Ляонин мужаас гадна Шанхай, Хубэй, Хунминь, Хэнаньд Гонконгчууд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа юм.

Мөн одоогоор Гонконгт Хятадын хөрөнгө оруулсан 1000 гаруй үйлдвэр-аж ахуйн газар байгаа нь Гонконгийн эдийн засгийн чухал хэсгийг бүрдүүлж байна. Эдний дотроос

Хуануны, Гуандагийн, Юэхайгийн болон Хятадын жуулчдын товчоо, Шанхайн ажил хэрэгч хувь нийлүүлэгчдийн компани зэрэг нь нэлээд нэрд гарчээ. 1991 оны 3-р сард Гонконг Хятадын үйлдвэрийн нийгэмлэг байгуулагдсан юм. 1991 оны эцсээр Хятадын хөрөнгө оруулсан 952 үйлдвэр, аж ахуйн газрын төлөөлөгчдийг энэ нийгэмлэг хүлээн авч уулзжээ. 1. Эднээс 922 нь өөрийн дэлгүүртэй байгууллага, 30 нь хувь хүмүүс байв. Энэ нийгэмлэгийн гол зорилго нь Гонконг дахь Хятадын капиталын хүчийг нэгтгэж улмаар Гонконгийг хөгжүүлэх, Гонконг-Хятадын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаанд тус дэмжлэг үзүүлэхэд оршиж байна. Ингэснээр Гонконг нь; 1. Сүүлийн жилүүдэд Хятадын хөрөнгөөр боссон үйлдвэрүүдийг аажмаар нэгтгэж чадсанаар санхүү, худалдааны талаар ашигтай ажиллаж байна. Гонконг нь Хятадтайгазар зүйн байрлалын хувьд ойр дэлхийн болон бүс нутгийн улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд нь Хятадын харах цонх болж байгаа юм. Гонконгийн Хятадтай өргөжүүлж буй харилцаа нь өөрийнх нь нэр хүндийг олон улсын санхүүгийн тавцанд улам бүр өргөж өгч байна. Өөрөөр хэлбэл Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил нь Гонконгийн хөгжлийн нэг баталгаа болж байна. Энэ нь сүүлийн 10 гаруй жилийн турш дахь эдийн засгийн хамтын ажиллагаанаас нь харагдаж байна.

2. Хятадын өмнөд муж, тухайлбал Гуандун мужийн Чжүзяны бүс нутаг нь Гонконгчуудыг хямд ажиллах хүч газар, түүхий эдээр хангаж байна. Үүнийг зөвхөн цалин дээр л жишээ авч үзье. 1989 онд Гонконгийн 1 ажилчны цалин жилд дундачаар 11000 доллар байхад Шэньжэны онцгой районд 1 ажилчны жилийн цалингийн хамгийн дээд хэмжээ нь 2500 доллар болж байгаа ба бусад муж, районуудад бол үүнээс бүр доогуур 600 доллар ч хүрэхгүй байна. Боловсруулах үйлдвэрт 3 сая хөлсний ажилчин 10 гаруй жил ажиллаж байгаагаас үзэхэд гонконгчуудын орлого тодорхой билээ. Мөн Гонконгчуудаас авах албан татвар хятадууд хөнгөлөлттэй нөхцөл үзүүлж байна. Энэ нь үйлдвэрлэлийн хэрэгсэл их хэмжээгээр оруулахад үзүүлж буй дэмжлэг юм. Иймээс ч Хятад улс нь Гонконгийн боловсруулах үйлдвэрийн нэг том бааз болж байгаа юм.

3. Гонконг нь Хятад-Тайваний харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй төдийгүй бусад улс орнуудад нийлүүлэх Хятадын барааг тээвэрлэн их ашиг олж байгаа юм. 1991 онд өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт буурсан байхад Гонконгийнх 4 дахин нэмэгджээ. Одоо Гонконг нь дэлхийн улс хоорондын худалдааны харилцаанд 10 дугаар байранд явж байна. Эдийн засгийн ийм хурдацтай хөгжлийн нууц юунд байна вэ? гэдэгт "Вэньхой" сонинд тэмдэглэсэнээр бол 1-рт Гонконгийн улс төрийн байдал тогтворжсон, 2-рт Хятадаас Англитай байгуулсан Гонконгт байгаа нисэх онгоцны шинэ буудлын тухай болон бусад олон хэлэлцээр, мөн 1989 оноос хямралдсан Хятад-Английн харилцаа харьцангуй намжмал байдалтай болсон. 3-рт Хятадын шинэчлэл, "нээлттэй хаалга"-ны бодлогын шууд нөлөөгөөр Гонконгийн хөрөнгө оруулалт, худалдаа Хятадад нэвтэрсэн.

4-рт Хятадад өөрийн үйлдвэр, завод барьж ашиглалтанд оруулсан Гонконгийн худалдаа үйлдвэрийн олон эзэд олон улсын зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 14 Дээр дурьдсанаас үзэхэд Хятад-Гонконгийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь бие биенээ нөхөн хөгжиж улмаар хөгжил цэцэглэлтийнхээ ид үед явж байна гэж дүгнэн хэлж болно.

#### НОМ ЗҮЙ

1. Гонконгийн аж үйлдвэрийн нийгэмлэгийн мэдээ 1992. 1.31.
2. Гонконгийн худалдаа 1992.1.31.
3. Мөн тэнд
4. "Вэньхой" 1992.2.7.
5. Хятадын худалдаа 1992.5.10.
6. "Жэньминь жибао" 1992.10.8.
7. "Жэньминь жибао" 1992.3.25.
8. "Бээжин жибао" 1990.6.13.
9. Гонконг Макаогийн эдийн засаг, 1992. №4. 15-р тал.

Хуануны, Гуандагийн, Юэхайгийн болон Хятадын жуулчдын товчоо, Шанхайн ажил хэрэгч хувь нийлүүлэгчдийн компани зэрэг нь нэлээд нэрд гарчээ. 1991 оны 3-р сард Гонконг-Хятадын үйлдвэрийн нийгэмлэг байгуулагдсан юм. 1991 оны эцсээр Хятадын хөрөнгө оруулсан 952 үйлдвэр, аж ахуйн газрын төлөөлөгчдийг энэ нийгэмлэг хүлээн авч уулзжээ. 13 Эднээс 922 нь өөрийн дэлгүүртэй байгууллага, 30 нь хувь хүмүүс байв. Энэ нийгэмлэгийн гол зорилго нь Гонконг дахь Хятадын капиталын хүчийг нэгтгэж улмаар Гонконгийг хөгжүүлэх, Гонконг-Хятадын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаанд тус дэмжлэг үзүүлэхэд оршиж байна. Ингэснээр Гонконг нь; 1. Сүүлийн жилүүдэд Хятадын хөрөнгөөр боссон үйлдвэрүүдийг аажмаар нэгтгэж чадсанаар санхүү, худалдааны талаар ашигтай ажиллаж байна. Гонконг нь Хятадтайгаар зүйн байрлалын хувьд ойр дэлхийн болон бүс нутгийн улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд нь Хятадын харах цонх болж байгаа юм. Гонконгийн Хятадтай өргөжүүлж буй харилцаа нь өөрийнх нь нэр хүндийг олон улсын санхүүгийн тавцанд улам бүр өргөж өгч байна. Өөрөөр хэлбэл Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил нь Гонконгийн хөгжлийн нэг баталгаа болж байна. Энэ нь сүүлийн 10 гаруй жилийн турш дахь эдийн засгийн хамтын ажиллагаанаас нь харагдаж байна.

2. Хятадын өмнөд муж, тухайлбал Гуандун мужийн Чжүзяны бүс нутаг нь Гонконгчуудыг хямд ажиллах хувьцаагаар газар, түүхий эдээр хангаж байна. Үүнийг зөвхөн цалин дээр л жишээ авч үзье. 1989 онд Гонконгийн 1 ажилчны цалин жилд дундачаар 11000 доллар байхад Шэньжэны онцгой районд 1 ажилчны жилийн цалингийн хамгийн дээд хэмжээ нь 2500 доллар болж байгаа ба бусад муж, районуудад бол сүүнээс бүр доогуур 600 доллар ч хүрэхгүй байна. Боловсруулах үйлдвэрт 3 сая хөлсний ажилчин 10 гаруй жил ажиллаж байгаагаас үзэхэд гонконгчуудын орлого тодорхой билээ. Мөн Гонконгчуудаас авах албан татвар хятадууд хөнгөлөлттэй нөхцөл үзүүлж байна. Энэ нь үйлдвэрлэлийн хэрэгсэл их хэмжээгээр оруулахад үзүүлж буй дэмжлэг юм. Иймээс ч Хятад улс нь Гонконгийн боловсруулах үйлдвэрийн нэг том бааз болж байгаа юм.

3. Гонконг нь Хятад-Тайваний харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй төдийгүй бусад улс орнуудад нийтлүүлэх Хятадын барааг тээвэрлэн их ашиг олж байгаа мөн. 1981 онд өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт буурсан байхад Гонконгийнх 4 дахин өсөжгджээ. Одоо Гонконг нь дэлхийн улс хоорондын худалдааны харилцаанд 10 дугаар байранд явж байна. Эдийн засгийн ийм хурдацтай хөгжлийн нууц юунд байна вэ? Гэдэгт "Вэньхой" сонинд тэмдэглэснээр бол 1-рт Гонконгийн улс төрийн байдал тогтворжсон, 2-рт Хятадаас Англитай байгуулсан Гонконгт байгаа нисэх онгоцны шинэ буудлын тухай болон бусад олон хэлэлцээр, мөн 1989 оноос хямралдсан Хятад-Английн харилцаа харьцангуй жижиг мал байдалтай болсон. 3-рт Хятадын шинэчлэл, "вээлттэй хаалга"-ны бодлогын шууд нөлөөгөөр Гонконгийн хөрөнгө оруулалт, худалдаа Хятадад өсөжгэжээ.

4-рт Хятадад өөрийн үйлдвэр, завод барьж ашиглалтанд оруулсан Гонконгийн худалдаа үйлдвэрийн олон эзэд олон улсын зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 14 Дээр дурьдсанаас үзэхэд Хятад-Гонконгийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь бие биенээ нөхөн хөгжиж улмаар хөгжил цэцэглэлтийнхээ ид үед явж байна гэж дүгнэн хэлж болно.

#### НОМ ЗҮЙ

1. Гонконгийн аж үйлдвэрийн нийгэмлэгийн мэдээ 1992. 1.31.
2. Гонконгийн худалдаа 1992.1.31.
3. Мөн тэнд
4. "Вэньхой" 1992.2.7.
5. Хятадын худалдаа 1992.5.10.
6. "Жэньминь жибао" 1992.10.8.
7. "Жэньминь жибао" 1992.3.25.
8. "Бээжин жибао" 1990.6.13.
9. Гонконг Макаогийн эдийн засаг, 1992. №4. 15-р тал.

10. Тайваньд 1992 онд болсон олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал 64-р тал.
11. "Жэньминь жибао" 1992.3.25.
12. Вэньхой 1992.2.7.
13. "Ляонин жибао" 1992.10.7.
14. "Вэньхой" 1992.1.1. /1992.1.1/